

“ХӨНГӨН БЕТОН”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 16-ний өдөр

№ 08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 69.1, 69.3, 69.6, дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ундрахад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.НАРАНЗУЛ

**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
АНХААРАЛД**

Компанийн тухай хуулийн 69.1, 69.3-д заасныг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүрээгүй тул хойшлогдсон хурлыг **2018 оны 04-р сарын 30**–ний өдрийн **17⁰⁰** цагт өөрийн байранд хийх болсныг мэдэгдье.

Харилцах утас: 99903777

Хаяг: ХУД 3-р хороо, Үйлдвэр /17061/ Эв нэгдлийн гудамж 19/1.

Шуудангийн хаяг: 36-р салбар ш/х-443

**“ХӨНГӨН БЕТОН” ХК
Хурал зохион байгуулах комисс**